



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 04 өдөр

Дугаар А/213

Булган сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацаа сунгах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 37 дугаар зүйлийн 37.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн хуралдааны IX/19 дүгээр тогтоолоор баталсан “Булган сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-г тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэн Ц.Уранчимэг (ГЮ72111000)-ийн Булган сум 6 дугаар баг Залуус 1 дүгээр гудамж 102а тоотод байршилтай 6308008201 нэгж талбар бүхий амины орон сууц зориулалтаар эзэмшиж буй 1980 м² газар, “Анхдагч-Аян ХХК (РД:3186245)-ийн Булган сум 5 дугаар баг Хатанбаатар С.Магсаржав 2 дугаар гудамж 216 тоотод байршилтай 6308003758 нэгж талбар бүхий худалдаа, үйлчилгээний зориулалтаар эзэмшиж буй 881 м² газар, “Стандарт, хэмжил зүйн хэлтэс” (РД:9011676)-ийн Булган сум 5 дугаар баг Хатанбаатар С.Магсаржав 2 дугаар гудамж 201 тоотод байршилтай 6308007255 нэгж талбар бүхий албан конторын зориулалтаар эзэмшиж буй 1026 м² газрын газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг тус тус 15 жилээр сунгасугай.

2. Иргэн Ц.Уранчимэг болон “Анхдагч-Аян” ХХК, “Стандарт, хэмжил зүйн хэлтэс” нартай газар эзэмшүүлэх гэрээг шинэчлэн байгуулж, гэрчилгээжүүлэн газар эзэмшилтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

3. Газрыг зориулалтын дагуу зүй зохистой эзэмшихийг иргэн Ц.Уранчимэг, “Анхдагч-Аян” ХХК, Стандарт, хэмжил зүйн хэлтэс (Ц.Бүрэнтуяа) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ

